



# НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2002 оны 01 дугаар  
сарын 30 ны өдөр

№ 14

Улаанбаатар  
хот

"Улаанбаатар сан" УУГ-ыг өөрчлөн  
зохион байгуулах тухай

Монгол улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 11 дүгээр зүйлийн 1 дүгээр заалт, "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дүгээр заалт, "Иргэний хууль"-ийн 30 дугаар зүйл, "Компаний тухай хууль"-ийг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. "Улаанбаатар сан" УУГ-ыг 2002 оны 1 дүгээр сарын 30-ны өдрөөс "Улаанбаатар сан" Хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ болгон өөрчлөн зохион байгуулсугай.

Хоёр. "Улаанбаатар сан" ХХК-ний дүрмийг нэгдүгээр хавсралтаар, "Улаанбаатар сан" ХХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хоёрдугаар хавсралтаар, хяналтын зөвлөлийн гишүүдийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт орж байгаатай холбогдуулан "Улаанбаатар сан" ХХК-ий бүтэц, орон тоог тогтоох, гүйцэтгэх захирлыг томилж ажиллуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл /М.Энхболд/-д даалгасугай.

Дөрөв. "Улаанбаатар сан" УУГ-ын эд хөрөнгө, эрх үүргийг "Улаанбаатар сан" ХХК-д шилжүүлсүгэй.

Тав. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1997 оны "Улаанбаатар сангийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай" 14 дүгээр тогтоол, 2000 оны "Сангийн үйл ажиллагааны тухай" 1 дүгээр тогтоол, 2000 оны "Сангийн дүрэм, хөрөнгө зарцуулах журмыг шинэчлэн батлах тухай" 50 дугаар тогтоол, 2000 оны "Нэр өөрчлөх тухай" 72 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨ-  
ЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧ-  
ДИЙН ДАРГА

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨ-  
ЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧ-  
ДИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮД

Т.БИЛЭГТ

Г.МАНАЛЖАВ

ГЯЛТАНЦЭЦЭГ

Г. БАДАМЖУНАЙ

Д. БААСАНСҮРЭН

Ц. БААТАРСАЙХАН

С.

У.

Г.



Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын Тэргүүлэгчдийн 2002 оны 14  
дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

## **Нийслэлийг хөгжүүлэх “Улаанбаатар сан” ХХК-ний дүрэм**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Компаний нэр: Нийслэлийн өмчит Нийслэлийг хөгжүүлэх “Улаанбаатар сан” Хязгаарлагдмал хариуцлагатай компани /цаашид “компани” гэх/.

1.2 Компани нь Монгол улсын Иргэний хууль, Компаний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль зэрэг холбогдох хууль болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр энэхүү дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулна.

1.3 Компани нь Нийслэл Улаанбаатар хотыг хөгжүүлэх, хот тохижилтийг сайжруулах, хотын төсөв санхүүгийн чадамжийг нэмэгдүүлэх, иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх үүрэг бүхий нийслэлийн өмч дээр үндэслэгдсэн, аж ахуйн тооцоотой өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллах хуулийн этгээд мөн.

1.4 Компанийг үүсгэн байгуулагч нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бөгөөд удирдах дээд байгууллага нь Төлөөлөн удирдах Зөвлөл байна. Зөвлөлийн дарга нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч байна.

1.5 Компани нь өөрийн тэмдэг, хэвлэмэл хуудас, харилцах данстай байна.

1.6 Компаний албан ёсны хаяг нь: Улаанбаатар хот 46, Сүхбаатарын талбай 11 нийслэлийн төр захиргааны 1 дүгээр байр

1.7 Компани нь хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэртэй байна.

1.8 Компани нь үйл ажиллагаагаа дараах чиглэлээр явуулна:

1.8.1 Нийслэл Уланбаатар хотын нийтийн аж ахуйг өргөтгөх, хот тохижилтыг сайжруулах, хүн амын үйлчилгээг боловсронгуй болгох, нийгмийн асуудлыг сайжруулах, эколог, байгаль орчныг хамгаалах зорилгоор үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, аялал жуулчлал зэрэг үйл ажиллагаа явуулах

1.8.2 Хотын төсвийн ачааллыг багасгах, санхүүгийн хөрөнгийг арвижуулах зорилгоор төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, тендер зарлах, сугалаа, хувьцаа, үнэт цаас гаргах зэрэг үйл ажиллагаа явуулж нийслэлийн эдийн засаг санхүүгийн шинэ бүтцийг бий болгоход дэмжлэг үзүүлэх

1.8.3 Олон улсын байгууллага, гадаад орны засаг захиргаа, бизнесийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран компаний үндсэн үүрэгт нийцсэн хүрээнд үйл ажиллагаа явуулах

1.8.4 Хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа явуулах

1.9 Компани нь өөрийн салбар эсвэл төлөөлөгчийн газрыг бусад аймаг, хот, гадаад улсад ажиллуулж болно.

1.10 Компани нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаандаа холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авсны дараа улсын бүртгэлд бүртгүүлж тухайн үйл ажиллагааг эрхлэнэ.

## **Хоёр. Компаний эрх, үүрэг**

2.1 Компаний хэлбэрийг өөрчлөх, өөрчлөн байгуулах, татан буулгах, компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлнэ.

2.2 Компани өөрийн үйл ажиллагаагаа бие даан хуулийн хүрээнд эрхлэн явуулна.

2.3 Компани үйл ажиллагаагаа хэвийн явуулах зорилгоор мэргэжил чадвар сайтай, дадлага туршлагатай хүмүүсийг иргэний болон хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулах, тэдний ажиллах нөхцөл, хөдөлмөрийн хөлс, урамшууллын хэмжээг тогтооно.



2.4 Компани төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, гадаадын байгууллагатай хамтран ажиллах гэрээ хэлцэл байгуулан ажиллана.

2.5 Компани өөрийн үйл ажиллагаатай холбоотой зарим зүйлийг хуулийн дагуу нууцлана.

2.6 Компани нь үндсэн хөрөнгөө холбогдох хууль тогтоомжид заасны дагуу эзэмшиж, ашиглана.

2.7 Компани нь өөрийн эд хөрөнгийн бүрэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмшиж ашиглана.

2.8 Компани нь Монгол Улсын Албан татварын хуулиудын заалтыг мөрдөн татвараа өөрөө тодорхойлж, сайн дураар төлнө.

2.9 Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай мэдээ мэдээллийг цаг тухай бүр эрх бүхий байгууллагуудад гаргаж өгнө.

2.10 Компани нь иргэний болон хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсад, байгууллага аж ахуйн нэгжийн өмнө хүлээсэн үүргүүдийг биелүүлнэ.

2.11 Компани нь нийслэлийн нийгэм, эдийн засгийн хөгжилд бололцооны хэрээр дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

2.12 Компани улсын бүртгэлийн гэрчилгээ авсан өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа эрхлэн явуулна.

### **Гурав. Компаний хөрөнгийн эх үүсвэр**

3.1 Компаний хөрөнгө нь дор дурьдсан эх үүсвэрээс бүрдэнэ.

3.1.1 Дотоод гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс өргөсөн хандив, буцалтгүй тусламж

3.1.2 Үйлдвэрлэл, үйлчилгээний үр дүнд бий болсон эд хөрөнгө

3.1.3 Санхүүгийн үйл ажиллагааны үр дүнгийн орлого

3.1.4 Өөрийн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн өөр байгууллагад байршуулснаас авах ногдол ашиг

3.1.5 Төрийн өмчөөс хууль тогтоомжийн дагуу хувиарлаж шилжүүлсэн хөрөнгө

3.1.6 Орон нутгийн үйлчилгээ үзүүлсний хөлс

3.1.7 Бусад эх үүсвэр

## **Дөрөв. Компаний хөрөнгө**

4.1 Компани өөрийн хөрөнгө буюу дүрмийн сан 389.150.601 төгрөгийн, үндэсний мөнгөн тэмдэгт /валют/-аас бүрдсэн нийт 1.645.827.482 төгрөгийн хөрөнгөтэй байна.

4.2 Компани өөрийн хуримтлагдсан ашгийн хэмжээгээр дүрмийн сангаа нэмэгдүүлж болно.

4.3 Шаардлагатай нөхцөлд дүрмийн санд шинээр хөрөнгө оруулна.

### **Тав. Компаний санхүүгийн тайлан, хяналт шалгалт**

5.1 Компани санхүүгийн тайлангаа Монгол Улсын "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль" , "Аудитийн тухай хууль"-ийн дагуу баталгаажуулан үүний үндсэн дээр татварын багц хуулийн заалтад нийцүүлэн тогтоосон хугацаанд татварын тайлан гаргаж тооцоо хийнэ.

5.2 Санхүүгийн тайланд дараахь бүрдэл хэсгүүдийг заавал оруулна.

5.2.1 Баланс

5.2.2. Орлого үр дүнгийн тайлан

5.2.3 Мөнгөн гүйлгээний тайлан

5.2.4 Хуримтлагдсан ашгийн тайлан

5.2.5 Тайлангийн тайлбар тодруулга, илтгэх хуудас

5.3 Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг гүйцэтгэх захирал хариуцана. Компанид хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа нягтлан бодогч энэ хариуцлагаас чөлөөлөгдөхгүй .

5.4 Хяналт, шалгалт, лавлагаа, түүх архивын зорилгоор дараах баримт бичгүүдийг хуульд заасан хугацаагаар хадгална:

5.4.1 Компаний дүрэм, түүнд орох өөрчлөлтүүд

5.4.2 Компаний улсын бүртгэлийн гэрчилгээ

5.4.3 Компаний дотоод бичиг баримт материалууд

5.4.4 Компаний салбар болон төлөөлөгчийн газрын дүрэм, гэрээнүүд

5.4.5 Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичгүүд

5.4.6 Компаний Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, шийдвэр, хурал зөвлөлгөөний тэмдэглэл, гүйцэтгэх захирлын тушаал

5.4.7 Санхүү аж ахуйн үйл ажиллагааны анхан шатны болон дэлгэрэнгүй бүртгэл, ня-бо бүртгэлийн баримт бичиг материалууд, тайлан тэнцэл, санхүүгийн бусад бичиг баримтууд

### **Зургаа. Компаний удирдлага**

6.1 Компаний удирдлага нь Төлөөлөн удирдах зөвлөл, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал байна.

6.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал ээлжит болон ээлжит бус байна.

6.3 Зөвлөлийн Хурал хуралдуулах тухай шийдвэрт дараах зүйлийг заана.

6.3.1 Зөвлөлийн Хурал хуралдуулах газар, өдөр, цаг

6.3.2 Зөвлөлийн Хурлын хэлэлцэх асуудал

6.3.3 Зөвлөлийн Хуралд оролцогсдын нэрсийн жагсаалт

### **Долоо. Төлөөлөн удирдах зөвлөл, түүний эрх**

7.1 Компаний эрх барих дээд байгууллага Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид "ТУЗ" гэх/ байна.

7.2 ТУЗ нь долоогоос доошгүй гишүүнтэй байна.

7.3 ТУЗ-ийн гишүүдийг Зөвлөлийн даргын санал болгосноор Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс томилно.

7.4 ТУЗ-ийн дарга, гишүүдэд олгох урамшлын хэмжээг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс тогтооно.

7.5 ТУЗ-ийн ээлжит хурлыг улиралд 1-ээс доошгүй удаа хуралдуулна

7.6 ТУЗ-ийн гишүүдийн олонхи оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

7.7 ТУЗ-ийн хуралд оролцож байгаа гишүүдийн олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.

7.8 ТУЗ-ийн гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд Зөвлөлийн даргын санал өгсөн талын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

7.9 ТУЗ-ын хуралд тэмдэглэл хөтөлж, тогтоол гаргана. Тогтоолд зөвлөлийн дарга гарын үсэг зурна.

7.10 ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд дараах зүйлийг тусгана:

7.10.1 Хурал хийсэн газар болон цаг

7.10.2 Хуралд оролцсон гишүүдийн нэр

7.10.3 Хурлаар хэлэлцэгдсэн асуудал

7.10.4 Санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал болон санал хураалтын дүн

7.10.5 Хурлаас гаргасан шийдвэр

Хурлын тэмдэглэлд хурал даргалагч гарын үсэг зурах бөгөөд тухайн тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцана.

7.11 Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг буруу хөтөлсөн явдал нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.

7.12 ТУЗ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

7.12.1 Компаний үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтооно

7.12.2 Компани, ТУЗ-ийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.

7.12.3 Компаний гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх, түүний эрх хэмжээг тогтооно.

7.12.4 Компаний гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний нөхцөл, түүнд олгох цалин, урамшууллын хэмжээг тогтооно.

7.12.5 Компаний жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргана.

7.12.6 Компаний тайлан тэнцэл, аудитын тайлан, гүйцэтгэх захирлын тайланг хянаж батлана.

7.12.7 Компаний салбар болон төлөөлөгчийн газрыг байгуулах, гэрээ хэлцэл хийх зөвшөөрлийг олгоно.

7.12.8 Компаний бүтэц, орон тоо, ажиллагсдын цалин, урамшууллын хэмжээг тогтооно.

## **Найм. Төлөөлөн Удирдах зөвлөлийн даргын эрх, үүрэг**

8.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих үүргийг гүйцэтгэнэ.

8.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын эзгүйд түүний үүргийг төлөөлөн удирдах зөвлөлийн даргын томилсон, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрлэсэн аль нэгэн гишүүн гүйцэтгэнэ.

8.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.

8.4 Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга компаний гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулж ажиллана.

8.5 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох, чөлөөлөх саналыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд, гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулж шийдвэрлүүлнэ.

8.6 Компаний үйл ажиллагааны тайланг жил бүр Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулна.

## **Ес. Гүйцэтгэх захирлын эрх, үүрэг**

9.1 Гүйцэтгэх захирал нь компаний дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлийн даргатай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компаний өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

9.2 Компаний хөрөнгийг энэхүү дүрэм, гэрээ, Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний дотор эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулна.

9.3 Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд гэрээ, хэлцэл хийх, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулна.

9.4 Гүйцэтгэх захирал нь компаний чиглэл зорилго, ажиллах журам, хэтийн төлөвлөгөөг боловсруулж ажиллана.

9.5 Гүйцэтгэх захирал нь төрийн хууль тогтоомж Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн шийдвэр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, энэхүү дүрмийг биелүүлж гүйцэтгэлийг хангана.

9.6 Гүйцэтгэх захирал нь компаний ажиллагсдыг томилж, чөлөөлөх ба тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулж гэрээний биелэлтийг хангаж ажиллана.



9.7 Гүйцэтгэх захирал нь бусад аж ахуйн нэгж, байгууллагад хавсран ажиллахыг хориглоно.

9.8 Гүйцэтгэх захирал нь Монгол улсын холбогдох хууль тогтоомж болон энэхүү дүрэм, гэрээг мөрдлөг болгож шударгаар ажиллана.

9.9 Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд тушаал гаргана.

9.10 Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө ажлаа хариуцан тайлагнаж, байгуулсан гэрээний биелэлтийг бүрэн хангаж ажиллана.

### **Арав. Хяналтын зөвлөл**

10.1 Хяналтын зөвлөлийг 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс байгуулна.

10.2 Хяналтын зөвлөл нь Компаний дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих, Төлөөлөн удирдах зөвлөл, Компаний болон гүйцэтгэх захирлын үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулна.

10.3 Хяналтын зөвлөл нь Компани болон гүйцэтгэх захирлын үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна.

### **Арван нэг. Компаний эрх бүхий ажилтнуудын хариуцлага**

11.1 Компани зөвхөн өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээнэ.

11.2 Компани иргэний болон хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс ажиллагсдын эрхийг зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээнэ.

11.3 Компаний гүйцэтгэх захирал, нягтлан бодогч нь гэрээнд заагдсан хугацаанд эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд тэдгээр нь өөрийн хууль бус үйлдэл болон эс үйлдэл үйл ажиллагаанаас учирсан хохирлыг хариуцана.

11.4 Компаний гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу хангалтгүй биелүүлсэн бол энэ нь нэг талын санаачлагаар уг гэрээг цуцлах /чөлөөлөгдөх, халагдах/ үндэслэл болно.

11.5 Компаний эрх бүхий албан тушаалтан нь компаний дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан дотоод журамд заасан үүргийг биелүүлж, компаний ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана. Төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрснөөс бусад тохиолдолд компаний нууц мэдээг гуравдахь этгээдэд дамжуулах, хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахыг хориглоно.

11.6 Хуульд өөрөөр заагаагүй бол компаний эрх бүхий албан тушаалтан өөрийн хууль бус үйл ажиллагаанаас компанид учирсан хохирлыг хариуцана.

11.7 Компани эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, түүний хэмжээг тогтоох асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээ, компаний дотоод журмаар тогтоох бөгөөд тэдгээрийн дагуу шийдвэрлэх боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

11.8 11.7-д заасны дагуу хэд хэдэн этгээд хариуцлага хүлээх бол тэд компаний өмнө хамтын хариуцлага хүлээнэ.

11.9 Компаний эрх бүхий албан тушаалтны санаатайгаар дараах хууль бус үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцана:

11.9.1 Хувийн ашиг сонирхлын үүднээс компаний нэрийг ашиглан аж ахуйн үйл ажиллагаа явуулах

11.9.2 Компанитай харилцагчдад хуурамч мэдээлэл өгөх

11.9.3 Компаний тухай хуулийн 95 дугаар зүйлд заасны дагуу компаний бичиг баримтыг хадгалаагүй байх

11.9.4 Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээ, компаний дүрмээр тогтоосон эд хөрөнгө захиран зарцуулах эрх хэмжээг хэтрүүлэх

11.9.5 Энд заасан хариуцлагыг Компаний тухай хууль болон бусад хуульд заасан бусад хариуцлагатай давхар хүлээлгэж болно.

## **Арван хоёр. Компанийг татан буулгах**

12.1 Компанийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон шүүхийн шийдвэрээр Монгол улсын Иргэний хууль, Компаний тухай хууль болон бусад хуульд заасан үндэслэлээр татан буулгана.

12.2 Компанийг татан буулгах, компаний үйл ажиллагааг дуусгавар болгох, компаний өр төлбөрийг барагдуулахдаа Компаний тухай хуулийн 27, 28, 29, 30 дугаар зүйлийг баримтлаж шийдвэрлэнэ.